



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр боловсролын салбарт хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд барьж ашиглалтад оруулсан 13 нэрийн, нийт 61,630,924,563.30 (жаран нэгэн тэрбум зургаан зуун гучин сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун жаран гурван төгрөг гучин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Оюумаа болон хавсралтад заасан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Зээлийн хөрөнгөөр 2022-2024 онд барьж ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003232

7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 27 дугаар сарын 20-ны өдрийн
127 дугаар тогтоолын хавсралт

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХҮРЭЭНД
/БОЛОВСРОЛЫН САЛБАР/ БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Аймаг, нийслэлийн өмчид хүлээн авч бүртгэх (хариуцах байгууллага)
1	51 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо/	2,017,172,927.80	БА-247/2022	Улаанбаатар (НӨХГ)
2	Шинэ сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 40 дүгээр хороо/	9,183,589,845.90	БА-165/2023	Улаанбаатар (НӨХГ)
3	22 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо/	3,371,519,642.50	БА-186/2023	Улаанбаатар (НӨХГ)
4	8 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/	5,684,413,781.30	БА-102/2023	Улаанбаатар (НӨХГ)
5	107 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 14 дүгээр хороо/	3,552,247,071.90	БА-001/2024	Улаанбаатар (НӨХГ)
6	110 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 15 дүгээр хороо/	3,264,459,294.10	БА-034/2023	Улаанбаатар (НӨХГ)
7	17 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо/	4,650,663,685.00	БА-063/2023	Улаанбаатар (НӨХГ)
8	Шинэ цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 7 дугаар хороо/	4,243,882,296.20	БА-179/2023	Улаанбаатар (НӨХГ)
9	18 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо/	4,611,993,241.40	БА-028/2024	Улаанбаатар (НӨХГ)

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Аймаг, нийслэлийн өмчид хүлээн авч бүртгэх (хариуцах байгууллага)
10	Шинэ цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 25 дугаар хороо/	2,395,513,621.80	БА-147/2024	Улаанбаатар (НӨХГ)
11	72 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо/	3,509,819,475.00	БА-182/2024	Улаанбаатар (НӨХГ)
12	5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Говьсүмбэр аймаг/	1,599,787,847.30	05	Говьсүмбэр (ОНӨГ)
13	Шинэ сургууль /Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг/	13,545,861,833.10	2024/11-Д	Дархан-Уул (ОНӨГ)
	НИЙТ ДҮН	61,630,924,563.30 (жаран нэгэн тэрбум зургаан зуун гучин сая есөн зуун хорин дөрвөн мянга таван зуун жаран гурван төгрөг гучин мөнгө)		